



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 777

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар (Налайх дүүрэг, 2-р хороо) “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгуудыг дахин төлөвлөн барилгажуулах ажлын гадна инженерийн шугам сүлжээ” ажлын хүрээнд бий болсон нийт 406,142,000.00 (дөрвөн зуун зургаан сая нэг зуун дөчин хоёр мянга) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.


2. “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал К.Эрдэнэбаярт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.



ДАРГА

Б. ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д. НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн
дугаар тогтоолын хавсралт

"УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГОД БҮРТГЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Тоноглолтын нэр	Байршил	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Бүртгэх нийт дун (төгрөг)
1	ХТП-ын барилга			2023.02.17	1	ком	134,265,000.00
2	Иж бүрэн тоноглолтой 10/0.4 кВ-ын S11-M-2*800 кВа чадал бүхий трансформатортой ком дэд өртөө	ХТП-7002	НД 2-р хороо Жаргалант, Т.Даваажавын гудамж, 26, 27-р байрны гадна цахилгаан хангамж	2023.02.17	1	ком	172,447,000.00
3	КШУЛҮ23-3*120			2023.02.17	10	м	8,155,000.00
4	Орон сууцны гадна цахилгааны кабель шугам	2*АВВГ-3*95+1*50	НД 2-р хороо Жаргалант, Т.Даваажавын гудамж, 27-р байрны гадна цахилгаан хангамж	2023.02.17	240	м	43,812,000.00
5	Орон сууцны гадна цахилгааны кабель шугам	2*АВВГ-3*95+1*50	НД 2-р хороо Жаргалант, Т.Даваажавын гудамж, 26-р байрны гадна цахилгаан хангамж	2023.02.17	м	260	47,463,000.00
Нийт дун							406,142,000.00 (дөрвөн зуун зургаан сая нэг зуун дөчин хоёр мянга)